

PRODUCTION



РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ



2021
ИННОВАЦИ

УРИА:
Шинэ санаагаа
шавхагдашгүй
нөөц, хөгжлийн
боломж болгоё

НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ
СУДАЛГАА ИННОВАЦИ

МЭНДЧИЛГЭЭ



Монгол улсад орчин цагийн боловсрол үүсэж хөгжсөний 100 жил, Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж байгуулагдсаны 55 жил, Дэлхийн багш нарын 27, Монголын багш нарын 55 дахь өдөр тохиож байна.

Эрхэм хүндэт багш нар, үе үеийн ахмад багш нар, сургуулийн нийт ажилтанууддаа багш нарын өдрийн мэнд хүргэж, ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Бид өдөр бүрээр, жил нэмэгдэхийн хирээр өсөж, хөгжиж, дэвшиж байдаг. Энэ их хугацаа бол бидний өсөлт, хөгжил, цэцэглэлт юм. Энэ бүгдийг түүхээсээ 3 цагийн хэлхээст харж болно.

Ирээдүйдээ бид чанартай сургалт, чадамжтай төгсөгчдийг бий болгох **“НЭЭЛТТЭЙ, НОГООН, ЦАХИМ”** сургуулийг төгөлдөржүүлэн үлдээхийн тулд хүн бүр, өдөр бүр хичээн ажиллах шаардлага бий болж байна.

Хүн бүрийн идэвхи, санаачилга, зүтгэл нь сургуулиа, сургалтаа улам их хөгжүүлж, чанартай болгох бөгөөд энэ бүхэн бидний үйл ажиллагааны инноваци, чанар, бахархал байх болно. Хичээн ажиллаж буй та бүхэндээ, амжилт, бүтээл гаргаж буй багш, ажилтанууддаа талархал илэрхийлье.

ЗАХИРАЛ Д.БУЯНДЭЛГЭР



УДИРТГАЛ

Инноваци нь “innovat” буюу шинэчилсэн, сайжруулсан гэсэн утгатай латин үгнээс гаралтай бөгөөд шинэ бүтээгдэхүүн, санаа эсвэл технологи бүтээх, сайжруулах гэсэн утга илэрхийлдэг. Инноваци нь цоо шинэ зүйл байх албагүй бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээнд мэдэгдэхүйц өөрчлөлт хийж, технологи нэвтрүүлсний үр өгөөж юм. Инновацийн хамгийн гол шинж чанар нь эдийн засгийн үр өгөөжийг авчирч, нийгмийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхэд оршдог байна.

Инноваци хийхийн тулд улс орнууд багагүй хөрөнгө, хүч зарцуулах болсон ба үүнийг зардал гэхээсээ илүү “хөрөнгө оруулалт” гэж харах нь зохистой гэмээр. Хэн нь илүү инноваци хийж байгаа эсэхийг тодорхойлдог нэгэн хэмжүүр бол Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр тооцоолон гаргадаг “Глобал инновацийн индекс” юм (WIPO, 2018). Тус индексийн үзүүлэлтээр Швейцар, Швед, Нидерланд, Америк зэрэг улс тэргүүлдэг бөгөөд Азийн улсуудаас Япон, БНСУ, Сингапур, БНХАУ зэрэг орнууд дээгүүр байранд жагсаж байна. Эдгээр улс орнууд инновацийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, субъектүүд хоорондын үр дүнтэй хамтын ажиллагааны механизм, уялдааг бий болгон, соёлыг төлөвшүүлэхэд гол анхаарлаа хандуулсан байна.

Инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ байгууллага гол төлөв өөрсдийн хүч, нөөцөөр хэрэгжүүлж байгаа бөгөөд 10 байгууллага тутмын 8 нь (судалгаанд хамрагдсан байгууллагын 82.0%) инновацийг бие даан хэрэгжүүлж байгаа үр дүн гарчээ.

Өрсөлдөх чадварыг тодорхойлох нэг чухал шалгуур нь инновацийн идэвхжил болж, улс орнууд өөрсдийн онцлогт тохирсон инновацийн бодлого, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. ҮУПК-ийн удирдах баг нь сургалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа инновацид зориулж патент, зохиогчийн эрх, ноу-хау, шинэ бүтээл, нээлт зэргийг нэвтрүүлэх, хөгжүүлэхээр зорьж байгаа бөгөөд энэ ч утгаараа нийт багш, ажилтны судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих, бүтээл, бүтээмжийг нэмэгдүүлэх шинэ санаа, оновтой бүтээлүүдийг “Нээлттэй сургууль, судалгаа инноваци” цахим сэтгүүлдээ цувралаар хүргэж байгаа билээ.



Цахим сэтгүүл №1



Цахим сэтгүүл №2



Цахим сэтгүүл №3



ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ 2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

Дэлхийн багш нарын 27 дахь, Монголын багш нарын 55 дахь удаагийн баярын өдрийг угтан Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шилдэг шалгаруулах “МБС-ын чанарын зарим асуудал” сэдэвтэлтгэлийн, Инноваци шингэсэн бүтээлийн уралдаанд оролцсон бүтээлүүдийн товчоон

Б.МЯДАГБАДАМ Зөвлөх багш, магистр /СУРГАЛТЫН МЕНЕЖЕР/
И.ОЮУНЧИМЭГ Тэргүүлэх багш, магистр /СУРГАЛТЫН АРГА ЗҮЙЧ, БАГШ/
Б.АНХБАЯР Тэргүүлэх багш, магистр /МТАЖ-ЫН ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧ, БАГШ/

СЭДЭВ: ЦАХИМ БА ТАНХИМЫН СУРГАЛТЫГ ХОСЛУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХАД “ЦАХИМ СУРГУУЛЬ” СУРГАЛТ УДИРДЛАГЫН СИСТЕМИЙН ҮҮРЭГ



Б.МЯДАГБАДАМ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн
сургалтын албаны менежер

- Боловсролын удирдлагын магистр
- Зөвлөх багш
- Насанд хүрэгчдийн заах арга зүй, чадамжийн үнэлгээ, заах арга зүй үндэсний сургагч багш



И.ОЮУНЧИМЭГ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн
сургалтын арга зүйч

- Боловсролын удирдлагын магистр
- Тэргүүлэх багш




Б.АНХБАЯР

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн
эдийн засгийн багш, МТАЖ тэнхимийн эрхлэгч

- Бизнесийн удирдлагын магистр
- Тэргүүлэх багш

ЦАХИМ БА ТАНХИМЫН СУРГАЛТЫГ ХОСЛУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХАД “ЦАХИМ СУРГУУЛЬ” СУРГАЛТ УДИРДЛАГЫН СИСТЕМИЙН ҮҮРЭГ

ОРШИЛ




Монгол улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг бие даан сурч амьдрах, ажиллах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино. Энэхүү эрхэм зорилгыг ханган биелүүлэхэд багш бидний үүрэг хариуцлага, сургуулийн удирдлагын бодлого зохицуулалт чухал үүрэгтэй билээ.

Дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан бүхий л шатны боловсролын үйлчилгээнд орчин үеийн мэдээлэл технологийн дэвшилд суурилсан цахим болон танхим хосолсон хэлбэрийг нэвтрүүлэх хэрэгцээ улам бүр нэмэгдсээр байна. Олон улсын судалгаа, туршлагаас харахад сургалтын энэхүү хэлбэрийг амжилттай хэрэгжүүлэхэд суралцагчийн сурах арга барил, хандлага, мэдээллийн технологийг ашиглах чадвар, цахим хэрэгсэл эзэмших боломж гэсэн 3 үзүүлэлт чухал юм. Үүнээс гадна сургуулийн зүгээс багш суралцагчдыг нэгтгэн холбох, цахим сургалтын материалыг боловсруулах, түгээх, хүртээмжийг чанаржуулах, хянах, үнэлэх гэх мэт бүхий л үйл ажиллагааг нэгтгэсэн цахим систем бүхий програм хангамжийг нэвтрүүлэх нь нэн чухал хүчин зүйл болж байна.

Иймээс энэхүү судалгааны ажлын хүрээнд цахим сургалтын үедашиглах програм хангамж, түүний ашиглалт, суралцагч, багш нарын арга барил, хандлага, сургалтын үр дүнг түүвэрлэн тойм шинжилгээ хийсэн. Эдгээр хүчин зүйлийн өнөөгийн байдлыг үнэлэх зорилгоор МБС-ын салбарын 20 сургууль, ҮУПК-ийн нэвтрүүлж буй сургалтын цахим системийн ашиглалтын талаар судлахаар 201 суралцагч, 68 багш, 20 удирдлагаас санамсаргүй түүврийн аргаар 3 бүлэг 28 асуулга бүхий судалгааг Google Form ашиглан авч, цахим сургалтыг хэрэгжүүлэхэд багш суралцагчдын оролцох боломжийг тодорхойлсон болно.

Сургууль, багшийн бүтээлч хандлага цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулалт, мэдээлэл технологи ашиглах боломж нөхцөл, зохион байгуулалтыг хэрхэн хангаснаар цахим сургалтын үр дүн шууд хамаардаг.



www.hicheel.pas.mn



СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ:



Орчин үеийн мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад:

- Чадварлаг ажилтан бэлтгэхийн тулд чанартай сургалтыг хэрхэн явуулах вэ?
- Сургууль цахим сургалтын үйл ажиллагааг хэрхэн дэмжих вэ?

Дээрхи асуултанд хариулахын тулд энэхүү судалгааны ажлыг хийлээ. Аливаа мэргэжлийн сургуулийн үр дүнг төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшингээр үнэлэгдэх тул МБС-ын байгууллагууд бүгдөөр өөрийн төгсөгчдийг ажилтай болоход дэмжлэг үзүүлэх олон талт ажлуудыг хийдэг ч төдийлөн өндөр үр дүн гарах нь бага байх хандлагатай байна.

Түүнчлэн цахим болон танхимын сургалтыг үр дүнтэй зохион байгуулснаар суралцагч төгсөгчдийг зөв хүн болгохын сацуу мэдээллийн эрин зуунтай хөл нийлүүлэн ажиллаж амьдрах боломж нөхцлийг

бүрдүүлнэ. Үүний тулд суралцах үедээ бие хүн болж төлөвшихийн сацуу бие даан суралцаж, чадавхижин, ажилтай болж чадна, ажилтай орлоготой сайхан амьдрана гэсэн хандлага төлөвшснөөр ажил эрхлэлт нэмэгдэх боломж бүрдэнэ. Энэхүү хандлага сургалтын байгууллагад суралцагчдын хувьд орхигдоод байгаа нь нууц биш зүйл юм. Иймээс суралцагчдын хандлага сургалтын эцсийн үр дүнд хэрхэн нөлөөлж буйг судлах шаардлага бий болсон.

Судалгааны үр дүнд цахим сургалтыг зөвхөн цар тахлын нөхцөлд бус цаашид улам хөгжүүлж, танхимын болон цахим сургалтыг хослуулан хэрэгжүүлэх шаардлага бий болж, сургуулийн удирдлага болон багш нар өөрийн үйл ажиллагаандаа эргэцүүлэл хийж, алдаа дутагдлаа засаж сайжруулах боломжтой боллоо.

СУДАЛГААНЫ АРГА:

- Түүврийн арга
- Тоон болон чанарын судалгааны арга
- Математик статистик боловсруулалтын арга
- Анализ синтезийн арга зэрэг аргуудыг ашигласан.

СУДАЛГААНЫ АЖЛЫН СУДАЛГДСАН БАЙДАЛ:

Цахим сургалтын талаар олон улсын түвшинд судалгаанууд байдаг ч сургууль багш өөрийн нөөц хүчин чадалдаа тулгуурлан МБС-д нийцүүлсэн цахим сургалтын систем боловсруулж хэрэгжүүлсэн туршлага ховор байдаг.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

ҮҮПК-ийн 2020-2021 оны хичээлийн жилд цахимаар сургалтад хамрагдсан 201 суралцагч, 68 багш, МБС-т үйл ажиллагаа явуулж байгаа төр хувийн хэвшлийн 20 сургуулийн 22 удирдах ажилтан, 43 багшийг хамарч судалгааг хийсэн болно.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ЗОРИЛГО:

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦАХИМ СУРГАЛТ, УДИРЛАГЫН СИСТЕМЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХАРГА ЗҮЙГ НЭВТРҮҮЛЭХ




ЗОРИЛТ:

- МБС-ын салбарын цахим сургалт, удирдлагын системийн хөгжүүлэлт, цахим сургалтыг зохион байгуулж буй арга туршлагыг нээн илрүүлэх
- Багш, суралцагчийн цахим сургалтын оролцоо, түүнийг “Цахим сургууль систем”-ээр удирдах арга зүйг нэвтрүүлэх
- Багшийн “Цахим сургууль систем”-ийн ашиглалт, сайжруулалт, сургалтын хэлбэрт тааруулан хөгжүүлэлт хийх арга зүйг түгээн дэлгэрүүлэх

Мэргэжлийн боловсролын сургууль нь цахим орчинд үйл ажиллагаандаа юуг өөрчлөх шаардлагатай байгааг судлахын тулд тэдний ашиглаж байгаа програмын ашиглалт, МБС-т хир нийцтэй байгааг 6 асуулгаар гарган авч, судалгаанд анализ хийн, дэвшүүлсэн хэрэгтэй санаануудыг өөрийн сургуулийн “Цахим сургууль систем”-д нэвтрүүлэх боломжийг эрэлхийлсэн.


Судалгааг Google form ашиглан явуулсан. Судалгаанд төрийн өмчийн 11, хувийн хэвшлийн 9 сургуулийн 22 удирдлага, 43 багш саналаа ирүүлсэн. Судалгаанд хамрагдсан сургуулиудын 55 хувь нь төрийн өмчийн, 45 хувь нь хувийн хэвшлийн, 70 хувь нь МСҮТ, 30 хувь нь политехник коллеж байлаа.

СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУД





СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ СУРГАЛТАД АШИГЛАЖ БАЙГАА ПРОГРАМ



Судалгаагаар МСҮТ,политехник коллежүүдийн 22 хувь нь Facebook,22 хувь нь Zoom,20 хувь нь Google meet,19 хувь нь Classroom,2 хувь нь Moodle,2 хувь нь Амжилт,2 хувь нь МБС-д зориулсан програм, 11 хувь нь Microsoft teams програм ашиглан цахим сургалтыг зохион байгуулж байна. Эдгээр сургалтын програмууд нь ихэвчлэн хөгжүүлэлт хийгдсэн,сургалтыг бүрэн удирдан хянах нөхцөл бололцооны хувьд хязгаарлагдмал гэж үзэж болно.

СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН АШИГЛАЖ БҮЙ ПРОГРАМ БА СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙЦЭЛ



Сургалтын байгууллагын одоо ашиглаж буй дээрх програмууд нь МБС-ын үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэх талаар судалгааг зураг №3-аас харж болно. Одоо ашиглаж байгаа програм хангамж нь интернетийн хурднаас ихээхэн шалгаалдаг,сургалтын хэрэглэгдэхүүнийг цахим орчинд байршуулахад багтаамжаас хамааралтай,өртөг өндөртэй,мэргэжлийн ур чадвар олгох сургалтад нийцэл муу, онолын мэдлэг түгээх боломжоор хангагдсан байдаг гэж сургалтын байгууллагын удирдах ажилтнууд үзсэн байна.

СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУД АШИГЛАЖ БАЙГАА ПРОГРАМАА ДҮГНЭСЭН БАЙДАЛ



Графикаас харахад сургалтын үйл ажиллагаанд интернетийн хурд бага шаарддаг,олон хэрэглэгч зэрэг хандахад хүндрэлгүй,цахим сургалтын мэдээллийн сан бүрддэг,багтаамж ихтэй,мэргэжлийн ур чадвар олгох сургалт явуулах боломжийг бүрдүүлсэн,дата бага зарцуулдаг,хэрэглэхэд хялбар өөрийн үйл ажиллагаанд тохирсон цахим програм хангамж зайлшгүй шаардлагатай байна.

НЭГТГЭСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ


МБС-ын сургалтын байгууллагын цахим програм ашиглалтыг сайжруулах талаар сургалтын байгууллагаас ирсэн саналыг нэгтгэвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Ашиглах ном сурах бичиг,гарын авлага байршуулах боломжтой байх
- Үнэ төлбөргүй,дата бага шаарддаг,ашиглахад хялбар
- Багтаамж сайтай,сургалтын бүхий л мэдээлэл авах боломжтой байх
- Төр,хувийн хэвшил гэж ялгахгүй нэгдсэн программ ашиглах хэрэгтэй.
- Мэргэжлийн сургалтад зориулсан байх
- Суралцагч багшид хэрэглэхэд хялбар платформ байх
- Цахим сан хангалттай бүрдүүлэх боломжтой байх
- Төрөл бүрийн статистик мэдээллийн баазыг татаж авах боломжтой
- Програмын хөгжүүлэлт хийх,цахим сургалт зохион байгуулах багшийн ур чадварыг хөгжүүлэх боломжтой цахим програм хангамжийг сургалтад нэвтрүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

“ЦАХИМ СУРГУУЛЬ” СИСТЕМ АШИГЛАЛТЫН СУДАЛГАА


“Цахим сургууль” систем ашиглалтын талаар багш суралцагчдаас дараах судалгааг авсан. Судалгаанд ерөнхий эрдмийн 21, мэргэжлийн 47, нийт 68 багш хамрагдсан.

БАГШ НАРЫН “ЦАХИМ СУРГУУЛЬ СИСТЕМ”-Д ХАНДАЛТ



“Цахим сургууль” системээр сургалтыг явуулах үед багш нарт тулгарч байсан бэрхшээлийн талаар судалж үзвэл 18% нь интернетийн хурднаас хамаарч гацах, 39% нь олон хэлбэрээр хичээлээ оруулах боломж зарим мэргэжлийн хувьд дутмаг, 14% нь интернетийн төлбөр бага шаарддаг, 8% нь мэдээллийн технологийн ур чадвар муу байсан зэргийг дурьдаж байна.

БАГШ НАРЫН “ЦАХИМ СУРГУУЛЬ СИСТЕМ”-Д ХАНДАЛТ




Системд багш нар сургалтын материалаа дараах хэлбэрээр байршуулж байсан.

- РРТ хэлбэрээр 68%
- Doc, Ece хэлбэрээр 3%
- Зурган хэлбэрээр 15%
- Видео ба аудио бичлэгээр 8%
- Бусад хэлбэрээр 6%



ЦАХИМ СУРГУУЛЬ СИСТЕМ ДЭХ СУРГАЛТЫН МАТЕРИАЛЫН ТӨРӨЛ, АШИГЛАЛТ



Багшийн хувьд “Цахим сургууль” системийг ашиглан сургалт явуулах үед хир нийцтэй байсан талаар нарийвчилсан асуулга авч дүгнэвэл:

- Сургалтын материал ашиглалт суралцагчдын хувьд хүртээмжтэй байсан 63%,
- Цахим хэлэлцүүлэг явуулах боломж бүрдсэн 51%,
- Гэрийн даалгавар шалгах боломж бүрдсэн 57%,
- Мэдлэгийг цахимаар шалгах / шалгалт авах / 54%,
- Ур чадварыг цахимаар шалгах 22%,
- Цахимаар суралцагчдад үнэлгээг ил тод болгох 59%,
- Цахимаар сургалтад хамрагдсан ирцийн бүртгэх, харах боломжтой 66%,
- Цахим номын сангийн үйлчилгээ авах боломжтой 49%,
- Цахим өргөдөл гомдол илгээх боломжтой 65%,
- Цахимаар хичээлийн хуваарь хүлээх авах бүрэн боломжтой хэмээн хариулсан байна.

НЭГТГЭСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

Эндээс дүгнэхэд цахим сургууль системээр сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, удирдах нь бусад ижил төрлийн програм хангамжуудаас илүү өөрийн сургалтын үйл ажиллагаанд тохирцтой болох нь харагдаж байна. Цаашид уг системийг сайжруулах хөгжүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох сургалтын материалыг боловсруулахад багш нарыг чадавхижуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд багтаамжийг нэмэгдүүлэх, олон хэрэглэгч зэрэг ороход гацалт үүсэхгүй байлгах серверийг бүрдүүлэх зэрэг асуудлыг анхаарч ажиллах шаардлагатай байна.


“Цахим сургууль” системийг сайжруулах талаар багш нараас ирсэн санал:

- Бичлэг видео оруулах боломж бүрдүүлэх
- Цахим хичээлийн санг боловсронгуй болгох
- Үнэлгээг илүү нарийвчлалтай болгох даалгавар дээр алдааг тэмдэглээд буцаах боломжтой болгох
- Нэг сэдвээр олон ангиас тестээр шалгалт авах нөхцлийг бүрдүүлэх
- Багш шалгаж, үзсэн даалгаваруудыг зэрэг идэвхижүүлж устгадаг болгох.
- Багш гэрийн даалгавар шалгах системийг сайжруулах
- Багшийн хөгжилд зориулсан сургалтын хэсэгтэй болох
- Файлын өргөтгөлийн сонголтыг нэмэгдүүлэх зэрэг санал ирүүлсэн байна.

СУРАЛЦАГЧДЫН ЦАХИМ СУРГУУЛЬ СИСТЕМ АШИГЛАЛТ


Судалгаанд мэргэжлийн боловсролын 450, техникийн боловсролын 87 суралцагч хамрагдсан. Цахим сургууль системийг судалгаанд оролцогчдын 88% байнга ашигладаг, Заримдаа ашиглаж байсан 9%, огт ашиглаагүй 3% нь байна.

БАГШ НАРЫН “ЦАХИМ СУРГУУЛЬ СИСТЕМ”-Д ХАНДАЛТ



Цахим сургууль системд нэвтэрч цахим хичээлээ бүрэн заах боломж бүрдээгүй бол шалтгааныг судалж үзэхэд интернетгүй орчинд байсан 24%, интернетийн хурд удаан байсан 34%, цахим сургууль системийн талаар мэдээлэл дутмаг байсан 14%, бусад шалтгаантэй 28% байсан гэж хариулсан байна.

ЦАХИМ СУРГУУЛЬ СИСТЕМЭЭР СУРГАЛТАД ХАМРАГДАХАД СУРАЛЦАГЧДАД УЧИРЧ БАЙСАН БЭРХШЭЭЛ




Суралцагчийн хувьд “Цахим сургууль” системийг ашиглан сургалт явуулах үед хир нийцтэй байсан талаар нарийвчилсан асуулга авч дүгнэвэл:

- Сургалтын материал ашиглалт 51%
- Цахим хэлэлцүүлэгт хамрагдах 57%
- Гэрийн даалгавраа илгээх 52%
- Мэдлэгээ цахимаар шалгуулах / шалгалт өгөх/ 45%
- Ур чадвараа цахимаар шалгуулах 29%
- Цахимаар өөрийн үнэлгээтэй танилцах 35%
- Цахимаар сургалтад хамрагдсан ирцийн бүртгэлийг харах 40%
- Цахим номын сангийн үйлчилгээ авах 19%
- Цахим өргөдөл гомдол илгээх 20%
- Цахимаар хичээлийн хуваарь хүлээх авах 100% гэж хариулсан байна.



СУРАЛЦАГЧДЫН ЦАХИМ СУРГУУЛЬ СИСТЕМ АШИГЛАЛТ



НЭГТГЭСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

Цахим сургууль системийг сайжруулах талаар суралцагчдаас ирсэн санал:

- Мэргэжлийн ур чадвар олгох хичээлүүдийн сургалтын материалын төрлийг нэмэгдүүлэх
- Интернет хурдаас хамаарахгүй болгох
- Мэдээллийн сангийн багтаамжийг нэмэгдүүлэх
- Даалгаврыг андуурч илгээсэн тохиолдолд буцаах
- Олон хүн зэрэг хандахад гацахгүй байх
- Цахим номын санг нэмэгдүүлэх



ДҮГНЭЛТ:



Сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн нь “сонголтгэхээсээ илүүтэй”, аюулгүй байдал-боловсрол хоёроо аль алийг нь харгалзаж рациональ тооцоогоор дэнсэлсэн “гаргалгаа” байлаа. Ихэнх сургалтын байгууллагууд, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч зэрэг сургалтын үйл ажиллагаанд оролцогчид энэ талаар туршлага багатай, бэлэн биш байснаас манай улсын боловсролын байгууллагуудад багагүй хүндрэлүүд үүсэж байсан. Гэвч бид асуудлыг шийдвэрлэхдээ цахим сургалтад цөөнгүй боломж, давууталууд байгааг илрүүлэн сургалтын үйл ажиллагааг цахим системээр удирдах, сургалтын бүхий л хэрэглэгдэхүүнийг цахимжуулахад сургалтын байгууллагуудын туршлагыг илрүүлэх зорилгын хүрээнд дээрх судалгааг хийлээ. Судалгааны ажлын үр дүнд дараах дүгнэлтүүдийг гаргаж байна. Үүнд:

- МБС-ын салбарын сургалтын байгууллагууд нь цахим сургалтын хэлбэрийг нэвтрүүлж, энэ чиглэлийн програм хангамж, платформуудыг эрчимтэй хөгжүүлж байна. Энэ үед бид хэрэгцээтэй олон аппликейшн, программ, платформуудыг зөв ашиглаж сурч байгаагаас гадна мэдээллийн сонголт хийх чадварыг хөгжүүлснээр орчин үеийн мэдээлэл технологийн дэвшил төдийгүй нийгэм, эдийн засгийн байдал мэргэжлийн боловсролын үйлчилгээг цаашид цахимаар эсвэл танхим болон цахим хосолсон буюу холимог /blended/, хосолмол /hybrid/, тонгоруу /flipped/ гэх зэрэг сургалтын аль нэг хэлбэрт хурдацтай шилжих нөхцөл бүрдүүлж байна.
- “Цахим сургууль” системийн хөгжүүлэлтийн нэвтрүүлэлт багш, суралцагч сургалтыг өөрөө удирдах боломжтой, ингэснээр өөрт илүү таатай, нийцтэй аргаараа суралцахуйн үйлийг явуулж, эдийн засагт хэмнэлттэй, ногоон хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Нөгөөтэйгүүр, цахимаар сургалт явуулахад багш, суралцагчаас хариуцлага, сурах, сургахуйн зорилгоо ухамсарласан байдал зэрэг хувийн чадвар, сахилга бат ихээхэн шаардагдаж байгаа нь өнөөгийн нийгэмд тулгарч буй хүн байхуйн асуудлыг шийдвэрлэхэд сайнаар нөлөөлнө гэж үзэж болох юм.
- Цахим сургалт удирдлагын нэгдсэн системийн хөгжүүлэлт нь сургалтын онцлогийг харуулах, сургах, суралцуйн зорилгоо ухамсарласан, суралцах хүсэл, хувийн хариуцлагатай байдлыг хянах, удирдах боломжийг бүрдүүлсэн боловч сургах зүйн талаас багшлах боловсон хүчнийг бэлтгэх, сургалтын хөтөлбөрийн дизайны болон хэрэглэгдэхүүнийг боловсруулах, сайжруулах, танхим болон цахим хосолсон сургалтыг нэвтрүүлэхэд онол, практикийн судалгааг олон талаас нь хийх, боловсролын суурь зарчимд түшиглэсэн туршилт сургалтууд хэрэгжүүлэх, судлагдахууны онцлогоос шалтгаалан сургалтын хэлбэрийг сонгох гэх зэргээр нэлээд шинжлэх ухаанч байр суурьтай, зохион байгуулалттай үйл ажиллагаа шаардлагатай болох нь харагдаж байна.
- Эцэст нь дүгнэхэд, бидуг судалгааны ажлаар дан танхимын хөтөлбөрөөр суралцаж байгаад давагдашгүй нөхцөл байдлын улмаас цахим хэлбэрт шилжсэн МБС-ын байгууллагууд, ҮҮПК-ийн удирдах ажилтнууд болон багш, суралцагчдын судалгаанд үндэслэн цахим сургалтын үйл ажиллагааны явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлсноор сургалтын үйл ажиллагаа хэвийн сургалтад оролцогчдын хүртээмж, чанар нь сайн байгаа нь цахим болон танхимын хосолсон сургалтыг нэвтрүүлэхэд эерэг үзүүлэлт гэж дүгнэж байна. Мөн багш, суралцагчдын цахим сургалт удирдлагын системийн ашиглалт, сургалтын удирдлагын хяналт, үнэлгээ нь судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын үнэлгээтэй хол зөрүүгүй байгаа нь цахим-танхим буюу хосолсон сургалтыг хөгжүүлэх боломжтой гэж харагдаж байна.
- Бидний хэрэгжүүлсэн энэхүү бичил судалгааны ажил нь өнөөдрийн сорилтыг боломж болгох оролдлого байсан ба Үйлдвэрлэл урлалын политехник коллежийг төдийгүй МБС-ын салбарын сургалтын байгууллагуудыг хосолсон сургалтын хэлбэрийг нэвтрүүлэх ажилд багахан хувь нэмэр оруулах байх гэж найдаж байна.

ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ 2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ


Магадлан итгэмжлэл нь чанарыг баталгаажуулах, аливаа үйл ажиллагааг байнга өөрчлөн сайжруулахад чиглэгдсэн удирдлагын үр дүнтэй арга хэрэгсэл бөгөөд байгууллага, хөтөлбөрийн гүйцэтгэлийн түвшин, уялдаа холбоо, чанарыг тодорхойлох, оролцогч талууд, олон нийтэд итгэл үнэмшлийг бий болгох систем гэж үздэг

Өнөөгийн нөхцөлд бүтээлч, авъяас чадвар, дасан зохицох чадвар, судалгааны сэтгэлгээг дээшлүүлэхийн тулд чанартай хөтөлбөр шаардлагатай байна. Дэлхий даяар өөрчлөгдөж буй шаардлагыг хангахын тулд хөтөлбөр нь тогтоосон хамгийн бага стандартыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах нь чухал юм.

Сургалтын чанарыг үнэлэхийн тулд чанарын баталгаажуулалтын хүчирхэг хэрэгсэл болох магадлан итгэмжлэлийг ашигладаг. Магадлан итгэмжлэлийг ЧАНАРЫН ТЭМДЭГ гэж үздэг бөгөөд энэ нь магадлан итгэмжлэгдсэн байгууллага, хөтөлбөрийг урьдчилан тодорхойлсон стандартын зарчимд үндэслэн гадны үнэлгээний хатуу процессыг даван туулж, хамгийн бага шаардлагыг хангасан байхыг баталгаажуулдаг

Б.МЯДАГБАДАМ Зөвлөх багш, магистр /СУРГАЛТЫН МЕНЕЖЕР/
И.ОЮУНЧИМЭГ Тэрүүлэх багш, магистр /СУРГАЛТЫН АРГА ЗҮЙЧ, БАГШ/

СЭДЭВ: МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ НЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАР, ИННОВАЦИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН АСУУДАЛ БА ДИЖИТАЛИЗМ



Д.ОДГЭРЭЛ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн сургалтын арга зүйч

- Боловсролын удирдлагын магистр
- Зөвлөх багш
- Чадамжийн үнэлгээ, заах арга зүй үндэсний сургагч багш
- Монгол улсын мастер үсчин



М.МӨНХЖАРГАЛ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн гоо заслын багш

- Арьс гоо заслын магистр
- Заах аргач багш
- Монгол улсын мастер гоо засалч
- Арьс гоо заслын технологич



ТОВЧ ХУРААНГУЙ

Магадлан итгэмжлэл нь чанарыг баталгаажуулах, аливаа үйл ажиллагааг байнга өөрчлөн сайжруулахад чиглэгдсэн удирдлагын үр дүнтэй арга хэрэгсэл бөгөөд байгууллага, хөтөлбөрийн гүйцэтгэлийн түвшин, уялдаа холбоо, чанарыг тодорхойлох, оролцогч талууд, олон нийтэд итгэл үнэмшлийг бий болгох систем гэж үздэг. Өнөөгийн нөхцөлд бүтээлч, авъяас чадвар, дасан зохицох чадвар, судалгааны сэтгэлгээг дээшлүүлэхийн тулд чанартай хөтөлбөр шаардлагатай байна. Дэлхий даяар өөрчлөгдөж буй шаардлагыг хангахын тулд хөтөлбөр нь тогтоосон хамгийн бага стандартыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах нь чухал юм. Сургалтын чанарыг үнэлэхийн тулд чанарын баталгаажуулалтын хүчирхэг хэрэгсэл болох магадлан итгэмжлэлийг ашигладаг. Магадлан итгэмжлэлийг **ЧАНАРЫН ТЭМДЭГ** гэж үздэг бөгөөд энэ нь магадлан итгэмжлэгдсэн байгууллага, хөтөлбөрийг урьдчилан тодорхойлсон стандартын зарчимд үндэслэн гадны үнэлгээний хатуу процессыг даван туулж, хамгийн бага шаардлагыг хангасан байхыг баталгаажуулдаг. Мэргэжлийн боловсролын чанарын баталгаа гэдэг нь мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагаа, сургах, сурах үйл ажиллагаа, материалаг орчин, төгсөгчдийн ажил эрхлэлт зэрэг үйл явцыг хамарсан бодит гүйцэтгэлтэй холбоотой ойлголт юм. Судалгааны ажлаараа мэргэжлийн сургуулиуд магадлан итгэмжлэлд хамрагдсанаар ямар өөрчлөлт гарч үр дүнд хүрсэн байгаа өнөөгийн байдал судалгаа хийж үнэлэлт, дүгнэлт өгч, дэлхийд дахин шинээр хэрэгжиж байгаа боловсролын инновацыг судалж улмаар өөрийн сургуулийн бодит жишээн дээр гарсан үр дүн юу болохыг тодорхойлохыг зорилоо.

ТҮЛХҮҮР ҮГ

Магадлан итгэмжлэл, боловсролын чанар, чанарын баталгаажуулалт, инноваци, дижитал сургалт

ОРШИЛ

Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн бодлого нь “Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон “Боловсрол үндэсний хөтөлбөр”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-той, засгийн газрын 2016 оны 304 дүгээр тогтоолын хавсралт “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” —тэй тус тус уялдаж, Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авъяас, сонирхолд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролыг шинэчлэн хөгжүүлж, чанар, хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино гэж зорилгыг тодорхойлсон байна. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 001 дугаар тогтоолоор “Мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага” шинэчлэн батлагдсан. Манай сургуулийн хувьд 3 мэргэжлээр (Үсчин, Гоо засал, Оёдол) Монгол улсад анх удаа магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөртэй мэргэжлийн сургууль болсон бөгөөд 2019-2021 онуудад 6 хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлээд байна. Сургалтын чанарын талаарх хариулыг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, бүс нутгийн болон дэлхийн хөгжил, технологийн хөгжлийн нарийн төвөгтэй байдал, нөөц, хөрөнгө оруулалт, зах зээлийн төлөөх өрсөлдөөн тасралтгүй өөрчлөгдөж буй байдлаас олж болно. Үйлдвэрлэлийн эрэлт хэрэгцээг хангаж буй хүчирхэг сургалтын суурь байхгүй бол эдийн засаг, бүтээмжийн уралдаанд ялагдана. Харин сургалтын чанар байхгүй бол систем үр дүнгүй, ашиггүй замбараагүй болно. Гадаад зохицуулалт, чанарын баталгааны тусламжтайгаар бид олон улсын шилдэг туршлага, МСҮТ-ийн тасралтгүй судалгаа, оролцогч талуудын зөвлөлдөөний үр дүнг энэ салбарт нэвтрүүлж, боловсролын бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан чанарын тогтолцоог бий болгох замаар МБС-ийн чанарыг баталгаажуулж үр дүнг дээшлүүхэд түлхэц болно гэж үзэж байна.

СУДАЛГАДСАН БАЙДАЛ



Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа бэхэжсэн дотоод чанарын баталгаажуулалтын мөн чанарын тогтолцоо аль хэдийн бүрэлдсэн орнуудад энэ сэдвээр олон судалгаа хийгддэг байна. Жишээ нь: Understanding education quality. EFA global monitoring report 2005.2021.UNESCO.(2015). Education 2030. Incheon Declaration and Framework for Action.UNESCO зэрэг болно. Манай мэргэжлийн боловсролын салбарт энэ сэдэв шинэ учир голчлон технологийн шилдэг бүтээл, оюуны өмчийн эрхийн гэрчилгээ зэрэг материалаг тал дээр хийгдсэн тухай бүтээлтэй холбоотой танилцуулга, судалгаа байдаг. Уг судалгаагаар боловсролын чанар, чанарын баталгаажуулалт нь сайн инноваци гарахад хэрхэн нөлөөлсөн талаар судалсан шинэлэн ажил болсон гэж үзэж байна.

ХАМРАХ ХҮРЭЭ


Боловсролын салбарт, мэргэжлийн боловсролын салбар

СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

Магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагаа, чанарын баталгаажуулалт, шалгуур шаардлагын дагуу сургалтын байгууллагад ямар ахиц дэвшил, бодит үр дүн гарч хэрхэн өөрчлөгдөж байгаа бодит жишээг дурьдаж инновацид хэрхэн хэрэгжиж бий болж байгааг тодорхойлсонд оршино.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:



Магадлан имтгэмжлүүлэх үйл ажиллагаа нь сургалтын чанар, чанарын баталгаажуулалтад хэрхэн нөлөөлж түүний үр дүнд шинэлэг бүтээлч ажлууд бий болж ямар үр дүнд хүрч байгааг илрүүлэхийг зорилоо.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТУУД:

- Боловсролын чанар, магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалт, инновацийн суурь ойлголт болон хамаарлыг судлах
- Байгууллага, хөтөлбөрийн магадланд хамрагдсан байгууллагын тоон судалгаа хийх
- Дэлхий дахинд гарч буй боловсролын инновацыг судлах
- Асуулга боловсруулан судалгаа хийж дүгнэлт гаргах
- Магадлан итгэмжлэлийн нөлөөллийн үр дүнд өөрийн сургууль дээр гарсан бодит өөрчлөлтийн тоймлох
- МБС-ын салбарт шаардлагатай асуудлыг хөндөж асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох




СУДАЛГААНЫ ХЭСЭГ

СУДАЛГАА 1: Улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн боловсролын салбарын судалгаа. Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 75 мэргэжлийн сургууль сургалтын үйлчилгээ үзүүлж байна.


№	Үзүүлэлт	Хичээлийн жил		
		2018-2019	2019-2020	2020-2021
1	Сургалтын байгууллагын тоо	86	80	75
1a	Үүнээс: Төрийн өмчийн	51	50	46
	Төрийн бус өмчийн	35	30	29
1б	Хотод	43	39	36
	Хөдөөд	43	41	39
	Гадаадад			
1в	МСҮТ	59	49	48
	ПК	16	23	23
	Их, дээд сургууль, байгууллагын дэргэдэх болон бусад сургалтын байгууллага /ангилал/	11	8	4

2021 ОНЫ БАЙДЛААР МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ПК, МСҮТ




Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд Монгол Солонгосын ПК-2, Хэнтий аймаг дахь ПК-2, УУПК-6, Архангай аймаг дахь “Гурван тамир” МСҮТ -1, МБС-8, ТБОС-3 мэргэжил тус тус хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж гэрчилгээгээ гардан авсан байна. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд хамрагдсанаар тухайн мэргэжлийн хувьдасар их хувь нэмэр оруулахын зэрэгцээ одоогийн нөхцөл байдлыг үнэлснээр цаашид хэрхэн яаж ажиллах талаар өгдөг зөвлөгөө нь хөгжил, дэвшил рүү хөтөлдөг нэг хөшүүрэг болж байна. Үүнийг судалгаа 2 дээр тодорхой дурьдах болно.

2021 ОНЫ БАЙДЛААР МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ТОО



СУДАЛГАА 1-ЫН ДҮГНЭЛТ: 2021 оны байдлаар ПК-3, МСҮТ-1 нийт 4 сургууль, МБС-8, ТБОС-3 нийт 11 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна. Дээрх 2 судалгаанаас харахад мэргэжлийн сургуулиудын магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимжиж 5 жилийн өмнө анх удаа магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо 6 байсан бол 2021 онд 17 болж 65%-иар огцом өссөн байна. Энэ нь ажиллагаандаа хөндлөнгийн, бодит үнэлгээ хийлгэж өөрийн үйл ажиллагааг сайжруулж байгаа нь харагдаж байна. Цаашдаа энэ тоо өсөх хандлагатай байгааг судалгаа 2 дээрээс харах боломжтой.

СУДАЛГАА 2 : Улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн сургуулиудаас авсан судалгаа. Судалгаанд 21 сургууль хамрагдсан ба 15 асуулгын хүрээнд судалгаа хийгдсэн.



Судалгаа 2 дүгнэлт: Мэргэжлийн боловсролын салбарт чанарын баталгаажуулалт аль хэдийн тогтворжиж хэрэгжээд байгууллагаа бүр өөрийн гэсэн туршлага хуримтлуулж чанарын баталгаажуулалтын ач холбогдолыг ойлгож үүний дагаж шинэ бүтээл технологиуд бий болж байна. Магадлан итгэмжлэлийг хөгжлийн нэг хөшүүрэг гэж тодорхойлж болно.

СУДАЛГАА 3: Магадлан итгэмжлэлийн үр дүнд өөрийн сургууль дээр гаргаж бодит жишээг тоймлон жагсаалтаар оруулав.

Судалгаа 3 дүгнэлт: Манай сургуульд магадлан итгэмжлэлд хамрагдсанаар салбартаа тэргүүлэх олон ажлыг санаачлан хийж салбартаа тэргүүлэх сургуулиудын нэг болж чадсан. Боловсролын магадлан итгэмжлэл нь дотоод чанарын баталгаажуулалтын гол түлхэц болох бөгөөд үүнийг дагасан шилдэг технологи, бүтээлүүд, салбарыг хөгжлийг дэмжих бүтээлч өрсөлдсөөн тасралтгүй бий болсоор байна.



НЭГДСЭН ДҮГНЭЛТ

- Мэргэжлийн боловсролын салбарын хөгжилд магадлан итгэмжлэл, дотоод чанарын баталгаажуулалт тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд шинэлэг бүтээлч байдлыг дэмжих нэг хөшүүрэг болж чадаж байна.
- Дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах суурь аль хэдийн тавигдсан бөгөөд дижитализмыг хөхүүлэн дэмжиж мэргэжлийн боловсролын салбарт дэлхийн шилдэг цахим технологиос нэвтрүүлэх бүтээлч санаачилгыг бодлогоор дэмжиж хөгжүүлэх шаардлага тулгарч байна.
- Сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд инновацийг нэвтрүүлэх талаар тодорхой бодлого байхгүй, мэдээллийн технологийг нэвтрүүлэх асуудлыг шинэ тоног төхөөрөмж, компьютер авч суурилуулснаар бүх зүйлийг шийдсэн мэт төөрөгдлийг арилгаж мэргэжлийн боловсролын салбарт дижитал инновацийг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой ажил хийх цаг болжээ.
- Технологийн шинэчлэлийг хурдасгах нэг хүчин зүйл бол интернетийн өргөн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх
- Боловсролын чанар, зах зээл, бизнес эрхлэлт, технологи, чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэл үйл явц нь инновацид (сургалтын байгууллагын хувьд сургалтын шинэ хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, шинэ сурах бичиг, сургалтын материал, цахим гарын авлага бэлтгэх зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, мэдээллийн технологи хэрэглэх замаар үйлчилгээгээ хүргэх шинэ үйл ажиллагааг нэвтрүүлэх, оюутан, эцэг эхчүүд, ажил олгогчидтой харьцах зохион байгуулалтын шинэ арга барил нэвтрүүлэх, эцэст нь сургалтын төлбөрөө ялгавартай болгох зэрэг маркетингийн шинэ аргууд) чухал нөлөө үзүүлдэг гэдэг нь тодорхой харагдаж байна. Боловсролын чанарыг баталгаажуулахын тулд бүх оролцогч талууд, байгууллагууд хамтын хүч чармайлт гаргах ёстой.
- Заавал хэн нэгний оролцоо, шахалт шаардлагаар биш олон улс болон улсын хэмжээнд байгаа бодлогын бичиг баримтад тулгуурлан чанарын баталгаажуулалтыг нэг мэргэжил, нэг салбар, байгууллага улсын цаашлаад дэлхийн хөгжлийн гарцыг тодорхойлох иж бүрэн тогтолцоог хэрэгжүүлэх нь илүү бодит, аливаа ухамсартайгаар хандах бүтээлч сэтгэлгээг бий болгох шаардлагатай байна.
- Аливаа зүйлийг сайжруулах гарц хөндлөнгийн үнэлгээ бөгөөд сургалтын иж бүрэн тогтолцоог, үйлдвэрлэлтэй хослуулан аль нэг тал руу туйлшрахгүй байх нь тогтвортой хөгжлийг хангах чухал үзүүлэлт юм.

ДЭВШҮҮЛЖ БҮЙ САНАЛ/ЗӨВЛӨМЖ

Мэргэжлийн боловсролын чанарын баталгааг хангахын тулд дараах ажлуудыг бодлогын түвшинд үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай болно.

- Засгийн газраас мэргэжлийн боловсролын стратегийн байр суурийг үнэлж, энэ салбарт төсөвт хуваарилах хөрөнгөө нэмэгдүүлэх.
- Засгийн газраас мэргэжлийн боловсрол эзэмшихэд шаардлагатай тоног төхөөрөмж, санхүүжүүлэх, хангах. Мэргэжлийн боловсролын үнэ цэнэ, ашиг тусын түгээх үүрэгтэй буй багш нарыг мэргэшүүлэх, давтан сургах нөхцлийг бүрдүүлэх ёстой.
- Магадлан итгэмжлэлийн сайн талыг сурталчилж энэ бол хөгжлийн гарц гэдгийг ухамсарлуулах
- Сургалтын технологиор үйлдвэрлэлд нэвтрүүлэх ашигтай загварыг хөхүүлэн дэмжих

Мэргэжлийн сургуулиудад түшиглэсэн үйлдвэрлэл инноваци, туршилтын төвүүдийг олноор бий болгох. Эцэст нь хэлэхэд, хүн төрөлхтний оюуны үнэт зүйл болон МОНГОЛ ХҮНИЙ үнэт зүйлд тулгуурласан, зөвхөн шинжлэх ухааны мэдлэг чадвар төдий бус сэтгэлийн боловсролыг хөгжүүлсэн, орчин үеийн дижитал эрин үед бэлтгэсэн, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх орчин нөхцлийг сайжруулж тэгш хамруулсан, сургалтыг чанаржуулах зүй тогтлоор нь өөрсдөө хэрэгжүүлж хөгжлийн гарцыг тодорхойлох цаг үе тулгараад байна.

ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ 2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

Спорт заалны электрон онооны самбарыг хэрэглэсэнээр багуудын оноо болон шүүгчийн шүүлт үзэгчдэд нээлттэй ил тод болдгоорой давуу талтай. Энэхүү электрон онооны самбарыг сагсан бөмбөг, гар бөмбөгийн спортын уралдаан тэмцээнд хэрэглэх бөгөөд бүх ЕБС, Их дээд сургууль, МСҮТ болон Политехник коллеж, Хувийн болон албан байгууллагуудын спорт заалнуудад хэрэглэхэд тохиромжтой.

П.ЧУЛУУНБАТ “Тэргүүлэх” багш, магистр /МЕХАТРОНИКИЙН БАГШ/
Н.ГАНБОЛД “Заах аргач багш,” магистр /МЕХАТРОНИКИЙН БАГШ/

СЭДЭВ: СПОРТ ЗААЛНЫ ЭЛЕКТРОН ОНООНЫ САМБАР



П.ЧУЛУУНБАТ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн
мехатроникийн багш

- Цахилгааны инженерийн магистр
- Инженер багш
- Тэргүүлэх багш



Н.ГАНБОЛД

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн
мехатроникийн багш


- Боловсрол судлалын магистр
- Заах аргач багш
- ABU goboson тэмцээний олон улсын шүүгч



ЛЕД ТЕЛЕВИЗОР БА ЭЛЕКТРОН ЦАГ

Лед телевизор , электрон цаг хийж ажиллуулсанаар түүнийг хийх арга техникийг сурах оюутанууд захиалгаар хийж өөрөө өөртөө ажлын байр бий болгох боломж бүрдсэн. Хэрэглэгчийн гарын авлагыг мэргэжлийн бус ямар ч хүн ашиглах боломж бүрдүүлсэнээрээ давуулболсон. Хотын соёлд нэмэр болохоос гадна манай сургуулийн ойролцоо явж байгаа иргэд цаг болон бусад нэмэлт мэдээлүүдийг дэлгэрэнгүй авах боломжтой.

Лед телевизор ба электрон цагийн өртөг өндөр дүнтэй байдаг. Бидний хийсэн бүтээлүүд 10 дахин бага үнэтэй байгаа нь зах зээлд илүү их борлогдох боломжтойгоос гадна оюутанууд илүү олон төрлийн бүтээл хийж өөрийн хувийн болон ажиллаж байгаа байгуулгадаа өөр төрлийн тоног төрөөрөмжийг хийж чадах чадвартай болсон нь юугаар ч үнэлж болошгүй хөрөнгө оруулалт гэж бодож байна. Энэ бүтээлийг хийхэд манай сургуулийн мехатроникийн ангийн оюутануудаас гадна гагнуур ,цахилгааны оюутанууд оролцож багаараа хамтарч хийсэн нь маш чухал давуу тал болсон.



ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ 2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ



С.ЭНХСАРУУЛ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн хүүхэлдэйн урлалын багш

- Боловсролын удирдлагын магистр
- Тэргүүлэх багш

СЭДЭВ: БААТАР

Баатрын хуяг дуулга, өмсгөл эдлэл хэрэглэлийн судалгаа хийж, түүнээс үндэслэн эх загвар болон ямар материалаар хийх, 1 хүүхэлдэйд орох материалын тооцоог нэг бүрчлэн гаргаж хийдэг ба дараах дарааллын дагуу бүтээлийг хийсэн.

- Судалгаа хийх
- Судалгаан дээр үндэслэн эх загваруудыг гаргах
- Эх загвараа батлах
- Материалын сонголт хийх
- Материалын тооцоо гаргах
- Материалаа авах
- Баримлаар толгой, гар, гутлыг барих
- Хэв авах /Резенин буюу зөөлөн хэв/ Холимон материалаар шахах
- Хуяг, дуулга, дээлний эсгүүр гаргах
- Кельше хэв дардас бэлдэх
- Арьсан дээр дардасаар дарах
- Толгой, гар, гутал, биеийг холбон угсрах
- Толгой, гар, гутлаа будах
- Нум, сум, саадаг хийж тогтоох
- Хүүхэлдэйгээ суурилуулах



Батлуулсан эх загварын дагуу баримлаар толгой, гар, гутлыг барина. Сүүлийн үед гадаад болон дотоодын уран бүтээлч ашиглаж хэв авдаг болсон зөөлөн материалаар хэв авч, 4-5 минутанд хатаж бэхэждэг холимог материалаар хэвэнд дарж гол бэлдэцүүдээ бэлдэнэ. Дээл хувцасны үлгэр гарган, тааран материал ашиглан эсгүүр хийн оёж, хуяг дуулгыг нь нимгэн арьсан дээр бэлдэц хэвээр даран, арьсны бүдгээр өнгө тавьж холбон угсарсан. Дүр төрхийг монгол зургийн шийдлээр, баримлан хэлбэрт оруулан өгсөн. Шинэ технологи арга ажиллагааг нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн аргаар хийх хүүхэлдэйн урлагийн хөгжилд томоохон ахиц гарсан гэж үзэж байна.



БҮТЭЭЛИЙН ТУХАЙ

Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд “Хувцастай хүүхэддэй хийх, Модон хүүхэддэй хийх” мэргэжлийн хичээлүүдээр суралцагчид бүрэн хамруулж, үйлдвэрлэлийн аргаар богино хугацаанд багаар ажиллах болон ганцаар ажиллах аргыг давхар эзэмшүүлж байна. Ингэснээр суралцагч ажлын байранд дээр гараад багаар болон ганцаар ажиллах ба дээрх бүтээл бүтээх арга технологийг ашиглан загвар дизайныг өөрчлөн өөрийн бүтээлийг урлан бүтээх чадамжтай болсон.

Тухайн бүтээлийг хийж байхад судалгаа гэж юу болох, тэрнийг хэрхэн бүтээлд ашиглах өөрийн санаагаа тусгаж бүтээлдээ шингээж сурдаг.


Бэлэг дурсгал нь ямар үйл явдал, ямар арга хэмжээнд бэлэглэх гэж байгаагаас шалтгаалан өөр өөр байдаг.

Бэлэг дурсгалын зүйлийг хэн нэгнээс авахад, түүнийг харах бүрд тухайн хүний амьдралд, тэр цаг үеийн агшин хором бүрийг байнга санагдуулан дурсамж болон үлдэгддэг.

Хийцийн гадна байдлын хувьд төстэй толгой, гар, гуталтай дээл хувцастай боловч сүүлийн шинэ технологи ашиглан хэв, цутгуур хийж, баатрын хуяг дуулгыг арьсаар хамгийн нарийн хээ гардаг лазер кильшегээр дардас бэлдэн, арьсаар товойлгон хийснээр илүү бодиттой болж өгсөн. Энэхүү баатрын зах зээлд худалдаалах үнэ хямд, авч явахад болон хүнд бэлэглэхэд тохиромжтой. Зах зээлд байгаа арьсан баатрууд хэмжээний хувьд том авч явахад төвөгтэй овор хэмжээ ихтэй, худалдааны үнэ өндөр байдаг.

Овор хэмжээ багатай, дүрийн хувьд хүүхдийн түр төрхтэй, монгол зургийн аргаар илэрхийлж өгсөн. Өмнө ашиглаж байсан шахмал материал удаан хатдаг, зүлгүүр их ордог цаг хугацааны хувьд удаан хийгдэг байсан. Энэхүү бүтээл нь уран бүтээлчдийн сүүлийн үед ашигладаг болсон зөөлөн хэв буюу резенээр хэв авч, богино хугацаанд олон тоогоор гарах боломжтой гүйцэтгэл илүү нарийн гардаг болсон. Оюуны өмчийн гэрчилгээг 2019 оны 12 сарын 02 өдрийн А/187 тоот тушаалаар 10 жилийн патентын эрх авсан.

Аялал жуулчлал хөгжиж байгаа цаг үетэй уялдуулан зах зээлд гаргах бүрэн боломжтой. Сургуулийн байрыг түшиглэн үйлдвэрлэл явуулах нь сургалтанд илүү ахиц дэвшил гарч байна. Сургуулийн бэлэг дурсгал болон захиалга аван суралцаж буй оюутнуудтай хамтран бүтээснээр үйлдвэрлэлийн дадлагын үйл ажиллагаа тасралтгүй хийгдэх болсон. Ингэснээр суралцагчид төгсөөд бие даан ажлын байртай болох, хийсэн бүтээлээ хэрхэн борлуулах талаар мэдлэгтэй болж зах зээлд өөрийн бүтээгдэхүүнээ гаргах бүрэн боломж бүрдэнэ.

ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

Д.НИНЖБАДГАР

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн
мэдээллийн технологийн багш

- Мэдээллийн технологийн бакалавр
- Заах аргач багш
- Мультимедиа үндэсний сургагч багш

Дэлхий нийтээр тархаад буй цар тахал болох COVID-19 өвчнөөс шалтгаалан дэлхий даяар бүх шатны сургалтын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжээд байгаа билээ. Энэ үед мэргэжлийн дадлагын хичээлийг хэрхэн цахим хэлбэрээр тохирсон сургалтын арга зүйг ашиглан явуулах нь маш чухал асуудал болоод байна. Мөн мэдээллийн технологийн мэргэжлийн дадлагын хичээлийн агуулга нь төрөл бүрийн програм хангамж болон кодчилолын хичээлд суурилдаг. Иймээс хичээлийг цахим хэлбэрээр явуулахад дараах хүндрэл бэрхшээл тулгараад байна. Үүнд:

- Суралцагч бүр компьютер ашиглах боломжгүй
- Багш болон суралцагч интректив байдлаар харилцах боломж бага
- Суралцагч бүрийн дэлгэцийг нэгэн зэрэг хянах боломж бага
- Тусгай хэрэгцээтэй суралцагчдыг тэгш хамруулах гэх мэт хүндрэлүүд тулгардаг.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭЖ, ҮР ДҮНД ХҮРСЭН АРГА ЗҮЙ:

- Мэдээллийн технологийн хөгжил дэвшил цаг тутамд маш хурдацтай хөгжиж байгаа нь бидний цахим сургалтын системийг чанартай хүртээмжтэй явуулах боломжийг хангаж өгч байна. Хэдийгээр суралцагч бүр компьютер байхгүй боловч гар утас ашиглаж байна.
- Мэдээллийн технологийн мэргэжлийн дадлагын хичээлд үздэг програм хангамжууд нь мөн ухаалаг утасны апплейкшн хувилбараар ашиглах боломж бүрэн байна. Жишээлбэл: Adobe photoshop програм хангамжийг танхимын хичээлийн үед зөвхөн компьютер суугдсан програм хангамжийг ашигладаг байсан бол цахим сургалтын үед online хэлбэрээр буюу www.photopea.com болон гар утасны photopea application ашиглах гэсэн хувилбараар ашиглаж болж байна. Цахим хичээлийн үед хэдийгээр суралцагчдад компьютер болон програм хангамж байхгүй ч гэсэн тухайн ур чадварыг online болон утас ашиглан эзэмших бүрэн эзэмших боломжтой юм.
- Мэргэжлийн дадлагын хичээлийн үед багш суралцагчдын интректив байдал маш чухал юм. Багш зөвхөн дэлгэцээ share хийж суралцагчид түүнийг харах бус суралцагч бүрийн хийж буй үйлдлийг багш хянаж зааж зөвлөх нь сургалтын чанарт чухал нөлөөтэй. Энэхүү байдлыг бий болгохын тулд суралцагч бүр дасгал ажлыг хийж гүйцэтгэх түүнийг багш засах хянах боломжтой интректив цагаан самбар /жишээлбэл jamboard, teams-ийн whiteboard гэх мэт/ ашиглах нь маш үр дүнтэй бөгөөд цаг хугацаа хэмнэсэн цахим сургалтын хэрэглэгдэхүүн болох юм. Суралцагч бүр ээлж дараалан дэлгэцээ хуваалцаж багшид шалгуулах нь цаг хугацаа шаардахаас гадна багш дэлгэцэнд засвар хийх боломжгүй тул төрөл бүрийн интректив white board ашиглах нь цахим сургалтын чанарыг дээшлүүлнэ гэж үзэж байна.
- Сургууль, багш бүр өөр өөрийн гэсэн цахим сургалт явуулдаг систем болон платформуудтай. Мэдээллийн технологийн мэргэжлийн хичээлийн хувьд ямар нэгэн програм хангамжийг судалдаг учир тухайн хүүхдийн хийж байгаа үйлдэл болон кодчилолын мөр бүхнийг нарийн хянах шаардлагатай байдаг. **Discord** ашиглан цахим сургалтыг ашиглан сургалт явуулах нь өрөө үүсгэж хүн бүрийн дэлгэцийг нэгэн зэрэг хянаж зааварлах боломжийг бүрдүүлж өгсөн.




УЛС, БҮСИЙН ЗААХ АРГА ЗҮЙТЭЙ БАГШ УРАЛДААН

ШИЛДЭГ АРГА ЗҮЙТЭЙ БАГШ-2021 УЛСЫН
УРАЛДААН

Овог, нэр: **Д.НИЖБАДГАР**
Байгууллагын нэр: **Үйлдвэрлэл урлалын политехник коллеж**
Ажилласан жил: **10**
Заадаг хичээл: **Мэдээлэл технологи**

Шилдэг арга зүйтэй багш улс, бүсийн уралдаанд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн. Энэхүү уралдаан нь цар тахалтай холбоотойгоор цахим хэлбэрээр явагдсан бөгөөд мэргэжлийн ур чадварын хичээлийг хэрхэн цахимаар олгож байгааг харуулсан гэдгээрээ онцлогтой байсан. Мэргэжлийн хичээлийг цахим хэлбэрээр явуулахдаа суралцагч бүрийн оролцоог жигд хамруулах, сургалтын явцад сонирхолтой жишээ баримт төсөөлөл бий болгох,


цахим хэлбэрээр суралцагч нэг бүр өөрийгөө үнэлэх, интерактив байдлыг хангах, суралцагч бүрийн дэлгэцийг хянах, мэдээллийн технологийн олон олон хэрэглэгдэхүүн програм хангамжийг ашиглах, компьютергүй суралцагчдад тухайн програм хангамжийг утсаар суралцах боломжийг олгох, тусгай хэрэгцээтэй суралцагчдад гэр бүлийн тусламжтайгаар тухайн ур чадварыг эзэмшүүлэх, веб-д суурилсан цахим хичээлийг бэлтгэн сургалтанд ашиглах, суралцагч төвтэй сургалтыг зохион байгуулсан зэрэг онцлог давуу талтай болсон гэж үзэж байна.



FLOWGORITH
M PROGRAM



FLOWDIA
LITE
APPLICATION

АЛХАМ 1
СЭРГЭЭН САНАЦГААЯ 2:00

БОДЛОГО

2 БҮХЭЛ ТООНЫ НИЙЛБЭРИЙГ ОЛОХ
АЛГОРИТМЫГ БЛОК СХЕМЭЭР
ИЛЭРХИЙЛ /jamboard буюу
интерактив самбар ашиглана уу /

ХҮҮХДҮҮДЭЭ БҮГДЭЭРЭЭ
ТӨСӨӨЛЦГӨӨ

ХИЙМЭЛ ОЮУН
УХААНТ РОБОТ

РОБОТООР ЯМАР ҮЙЛДЭЛ
ХИЙЛГЭХ БАЙСАН БЭ???

Бодлого бод.

1. ДЭВТРЭЭ НЭЭ
2. БАЛАА АВ
3. БОДЛОГЫН
НӨХЦӨЛӨӨ УНШ
4. БОДЛОГО БОДОХ
АРГЫГ ОЛ
5. БОДЛОГОО БОД

АЛИВАА АЖИЛ БОЛООД
ҮЙЛДЛИЙГ ҮР
БҮТЭЭМЖТЭЙГЭЭР
ОНОВЧТОЙ ГҮЙЦЭТГЭХ АРГА
ЗАМЫГ **АЛГОРИМТ** ГЭНЭ.

ҮНЭЛГЭЭНИЙ ЗААВАРЧИЛГАА

АЛХАМ 1	АЛХАМ 2	АЛХАМ 3	АЛХАМ 4	Хүн	БҮТ
1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30
31	32	33	34	35	36
37	38	39	40	41	42
43	44	45	46	47	48
49	50	51	52	53	54
55	56	57	58	59	60

Цахимаар заах хэсэг

ninjee.pas.mn ВЕБ-Д
СУУРИЛСАН ЦАХИМ
ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХЭСГЭЭС
АЛХАМ БҮРИЙГ ҮНЭЛГЭЭНИЙ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДАГУУ
1 МИНУТЫН ХУГАЦААНД 0-2
ОНООГООР ҮНЭЛНЭ.

Мэдээллийн технологи хурдацтай хөгжиж байгаа энэ цаг үед сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр үр дүнтэй явуулах мөн түүнчлэн ямар ч дадлаын хичээлийг цахимаар явуулж ур чадвар эзэмшүүлэх боломжтой гэж үзэж байна.

ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

Н.АЛТАНСУВД

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн
Монгол хэл бичиг, уран зохиолын багш

- Боловсролын технологийн ухааны докторант
- Дадлагажигч багш

Дэлхийн аль ч өнцөгөөс өөрийн хүссэн мэдлэг боловсрол, мэргэжлийг эзэмжих боломж бүрдсэн техник технологийн хөгжлийн эрин зуунтай хөл нийлүүлэн алхахын тулд бид өөрийгөө хөгжүүлэх, өдөр тутамдаа суралцах шаардлага бий болсоор байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд Ковид-19 хэмээх цар тахал дэлхий дахиныг нөмөрснөөр манай орны төдийгүй дэлхийн бүхий л улсад боловсролын салбарын шинэчлэл эрчимтэй хөгжиж буй нь нэг талаар сайшаалтай гэмээр. Түүнийг дагаад багшлах боловсон хүчин болоод багшийн хувийн ур чадвар, техник технологийн хэрэглээний мэдлэгээ ахиулж цахим сургалтыг амжилттай зохион байгуулах, суралцагч нарт үр дүнтэй, бүтээмжтэй, хүртээмжтэй байлгах нь бидний үүрэг юм. Тиймээс энэ хичээлийн жилд өөрийн мэргэжлийн төдийгүй техник технологийн, цахим хичээл боловсруулах, түүнийг амжилттай өгөөжтэй зохион байгуулах чадвараа ахиулахад ихэд ач холбогдол өгч ажиллан түүнийхээ үр дүнг мөн оны хичээлийн жилд зохион байгуулагдсан “Шилдэг арга зүйтэй багш Улсын уралдаан”-д Монгол хэлний хичээлийн “Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ” сэдвээр оролцож дэд байр эзэлсэн билээ.

Монгол хэлний хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад хэдхэдэн хүндрэл тулгарч байсан бөгөөд тэрхүү хүндрэлийг даван туулах арга замыг эрэлхийлэн ажиллах явцад дараах санаа урган гарсан болно.

- Хичээлийн хоорондын уялдаа холбоо
- Техник технологийн мэдлэг чадварын түвшин харилцан адилгүй байдал
- Үнэлгээний аргын сонголт, үнэлэх хэлбэр
- Хүүхэд бүрийн оролцоог хангах

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭЖ, ҮР ДҮНД ХҮРСЭН АРГА ЗҮЙ:

Зөвхөн мэдээллийн технологийн багш л МХХТ-ийн мэдлэг чадварыг эзэмшсэн байх ёстой гэх ойлголт хэдийнээ үгүй болж боловсролын салбарт төдийгүй бусад бүхий л салбарт энэхүү техник технологийн мэдлэгийн хэрэгцээ шаардлага бий болоод буй өнөөдрийн нийгэмд бид цаг, минутыг ч сул орхилгүй өөрийн сургалтаа суралцагч нартаа чанартай, үр дүнтэй хүргэх тал дээр өдөр тутмынхаа сургалтын үйл ажиллагааг ажиглаж судалж бодитой үр дүнг тооцож ажиллах нь чухал болоод байна. Үүний тулд техникийн ямар ч эх үүсвэрээс (тухайлбал утас, зөөврийн болон суурин компьютер) суралцагч таны хичээлийг хүлээж авах боломжтой байх нь хүртээмжийг нэмэгдүүлэх юм.

Монгол хэлний хичээл хэдий ч тухайн суралцаж буй мэргэжилтэй нь холбон заах нь суралцагчдын сонирхол болон оролцоог нэмэгдүүлэх бас нэгэн арга юм. Энэхүү хичээлээр “Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр түүний утга бүтэц хэрэглээ” сэдвийн хүрээнд Гоо засалч-1а ангид хичээл заасан бөгөөд Гоо заслын мэргэжилтэй нь холбон хичээл хоорондын интеграцийг үнэлгээ болоод ажиллаж буй дасгал дээр оруулж өгснөөрөө онцлог болсон.



УЛС, БҮСИЙН ЗААХ АРГА ЗҮЙТЭЙ БАГШ УРАЛДААН



**ШИЛДЭГ АРГА ЗҮЙТЭЙ БАГШ-2021 УЛСЫН
УРАЛДААН**




Овог, нэр: **Н.АЛТАНСУВД**
 Байгууллагын нэр: **Үйлдвэрлэл урлалын политехник
колледж**
 Ажилласан жил: **7 / МБСБ-д 5**
 Заадаг хичээл: **Монгол хэл, бичиг, уран зохиол**

Улс, бүсийн шилдэг заах арга зүйтэй
багш уралдааны дэд байр

Сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахдаа үнэлгээг өөрөөр нь хийлгэх, даалгаврыг гүйцэтгэж буй алхам тутамд үйлчлүүлэгчийн нүүр будалтын нэгээхэн алхамыг амжилттай хийж хичээлийн төгсгөлд үйлчлүүлэгчийн нүүрийг будаж нүүр дүүрэн инээмсэглэл сэтгэл хангалуун байдлыг бий болгох зорилго тавин ажиллуулснаар суралцагчдын идэвх оролцоо улам бүр нэмэгдсэн.


Хичээлийн төгсгөлд Google form дээр асуулга боловсруулж тухайн хичээлийн хэрхэн ойлгосон түвшинг тодорхойлсон тестийг утаснаас QR код уншуулж орох байдлаар тохируулж өгсөн болно. Ингэснээр суралцагчдад линкээр ороход алдаа гарах болон буруу линкээр орох зэрэг эрсдэлгүй болсон. Мөн үр дүнг нь тухайн цагт шууд харуулах боломж нөхцөл бүрдсэнээрээ давуу талтай байв.



Өөрийн үнэлгээний хуудас

Үнэлгээний шалгуур	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Муу
Зэрэгцэн нийлмэл асууларийг ялгах				
онцлогийг танин мэдсэн эсэх				
Зэрэгцэн нийлмэл асууларийн хэлбэр хэрэгсэлтийг ажиг тодорхойлж чадсан эсэх				
Зэрэгцэн нийлмэл асууларийг зөв хэлбэр найруулсан эсэх				





СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЭХЛЭЛ, ЦАХИМ НИЙТЛЭЛИЙН ГУРАВ ДАХЬ БҮТЭЭЛИЙН УРИАЛГА:

Энэхүү цахим цуврал сэтгүүлийг ҮУПК-ийн багш ажилтнуудын 2021-2025 оны стратеги төлөвлөлт хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд зориулан бүтээв. Сэтгүүлийг жилд 2 удаа гаргах бөгөөд тус сургуулийн инноваци, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүн, шинэ санаа, оновчтой туршилт ажлын амжилтахиулж, нэмэгдүүлсэн цаашдын хөгжлийг тодорхойлох бүтээлүүдийг танилцуулж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор нийтэлнэ.

Эрдэм шинжилгээний бүтээлүүдийн эхлэл нь мэргэн байж, цаашдын сургалт үйлдвэрлэл шинэ санаа оновчтой бүтээлийг дэлгэрүүлэн хөгжүүлэх үйлсэд хамт олноороо мэргэших болтугай.

2021 ОНЫ МБС-ЫН САЛБАРЫН “ИННОВАЦИ ШИНГЭСЭН БҮТЭЭЛИЙН УРАЛДААН АМЖИЛТТАЙ ОРОЛЦСОН БҮТЭЭЛИЙГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.

САНААЧИЛАН БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР Б.МЯДАГБАДАМ
ХЯНАСАН: МБС-ЫН ЗӨВЛӨХБАГШ Д.БУЯНДЭЛГЭР
ЭХ БЭЛТГЭСЭН: Д.НИНЖБАДГАР
ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛСЭН: Э.ТҮВШИН